



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/334

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.5 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 186 дугаар тогтоолын 2, 3-р зүйл, аймгийн Засаг даргын 2017 оны 03 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд байгалийн гамшиг, ган, зудаас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын төсвөөс санхүүжигдэх "Өвс нийлүүлэх ажил"-ын гүйцэтгэгчээр "Морьт боржигон" ХХК-ийг сонгон 40,000,000 /дөчин сая/ төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан өвсний үзүүлэлтийн дагуу шаардлага хангасан өвс нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хүлээлгэж өгөхийг "Морьт боржигон" ХХК-ний захирал /Ё.Дашням/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхжаргал/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200910